



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН  
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХҮН НАМД

2024.08.08 № 336

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024оны Архангай аймгийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "ХҮН нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

650230502

## Дүгнэлт

“ХҮН нам”-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“ХҮН нам”-ын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Архангай аймгийн сонгуулийн хороо”-нд

Хавсралт..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



ХҮН НАМ  
АРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

“ХҮНИЙ ХӨГЖИЛ НУТГИЙН ХӨГЖИЛ”  
2024-2028


АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024  
ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ЭРДЭНЭБУЛГАН СУМ  
2024 ОН

## АГУУЛГА

ОРШИЛ.....	2
I. “ХҮНИЙ ХӨГЖИЛ-НУТГИЙН ХӨГЖИЛ” ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО.....	4
II. “БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО .....	7
III. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ .....	12
IV. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ХҮН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО .....	144
V. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ .....	166



## ОРШИЛ

ХҮН намын Архангай аймгийн намын хорооны 2024 оны Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засаж, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтыг ханган биелүүлэх хүрээнд, нотолгоонд суурилж, судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Улс орны хөгжлийн түвшин, бус нутаг дахь аймгийнхаа онцлог, давуу байдалд үндэслэн хөгжих зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлж, орон нутгийн хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай.

Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд аймаг, сумын иргэн ХҮНИЙ ТӨЛӨӨ хүний хөгжлийг эн тэргүүнд тавьж, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг чиглүүлэх юм. Монгол Улсын орчин, нөхцөл байдал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг харгалzan үзвэл дараах 3 чиглэл онц ач холбогдолтой бөгөөд эдийн засаг, нийгмийг хөгжлийн замд гаргахад түлхэц болно гэж бид үзэж байна. Үүнд:

- (1) **Хүний хөгжил.** Боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилд тууштай, бодитой хөрөнгө оруулах. Энэ асуудал өнөөдрийн Монгол улсад, аймаг орон нутагт нэн тулгамдсан, хойш тавих боломжгүй асуудал бөгөөд дунд болон урт хугацаан дахь олон чухал асуудлын шийдэл нь хүний хөгжил юм.
- (2) **Технологийн хэрэглээ.** Блокчайн, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх түвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэн, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь түрүүлж хүртэнэ.
- (3) **Байгальд ойр Монгол.** Байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан уламжлалт монгол сэтгэлгээ, нүүдлийн соёл, амьдралын амар тайван хэв маягийг технологийн шийдэлтэй хослуулан аймгийн төв болон сумдын төвийн гэр хорооллыг хөгжүүлж, дэлхий дахинд ялгарах шинэ Монгол дүр төрх бүрдүүлнэ.

Аймгийн иргэдэд хурд, хүч, ялгарлыг өгөх дээрх гурван тулгуурт үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой бодлогын арга хэмжээг дараах 5 бүлэгт ангилан оруулав. Үүнд:

1. **“ХҮНИЙ ХӨГЖИЛ-НУТГИЙН ХӨГЖИЛ” ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО -** Хүндээ зориулсан хөрөнгө оруулалт – хотууд, орон нутгийн хөгжлийн ялгааг бууруулна
2. **“БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО -** Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна
3. **ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ -** Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө.
4. **БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ХҮН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО -** Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана.

5. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ – Төрийн үйлчилгээг иргэн тус бүрд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.

## 1. “ХҮНИЙ ХӨГЖИЛ-НУТГИЙН ХӨГЖИЛ” ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.1. Хүндээ зориулсан хөрөнгө оруулалт-өрсөлдөх чадвартай боловсрол

- 1.1.1. Цэцэрлэг, сургуулийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд мэргэжлийн байгууллагын дүгнэлт хийлгэж, хүүхдэд ээлтэй гадаад орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.2. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт, хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.1.3. Цэцэрлэг, сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурах, ашиглах бүрэн боломжтой байх стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, багш ажиллагсдын хөгжлийг дэмжсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Төрөлжсөн сургууль
- 1.1.5. Алслагдсан бүс нутагт амьдарч байгаа хүүхэд, залуучуудын боловсролд онцгой анхаарч, зайны сургалтын орчин үеийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Бүх насны иргэд тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлж, насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.6. Алслагдсан бүсэд багшлах багш нарыг бодлогоор дэмжиж, ажиллана.
- 1.1.7. Сургуулийн барилгын зураг төслийн зардлыг хэмнэх зорилгоор стандарт, зураг төсвийг орон нутгийн 65 онцлогт тохирсон ижил стандартуудтай болгоно.
- 1.1.8. Алслагдсан сум, багийн цэцэрлэг, сургуулиудын суралцагсдын дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, ариун цэврийн байгууламжийг сайжруулахад анхаарна.
- 1.1.9. Сургууль, цэцэрлэгийн суралцагсад болон багш ажилчдын хөгжих, суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Сайн сургууль
- 1.1.10. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг жил бүр хийж, боловсролын чанарт ахиц гаргасан багш, сургалтын байгууллагыг дэмжинэ.
- 1.1.11. Аймгийн хэмжээнд “Хос хэлтэн” болох зорилт тавьж, зохих бэлтгэл ажлыг хэрэгжүүлнэ. Гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- 1.1.12. Үе тэнгийн дээрэлхэл, гадуурхалтыг арилгах, хүүхдэд аюулгүй цахим орчныг бүрдүүлэхийг дэмжинэ.
- 1.1.13. Хүүхдийн зүй бус, албадан хөдөлмөр, мөлжлөгийг устгах, сургууль завсардалтыг үндсээр нь халахад анхаарч ажиллана.
- 1.1.14. Цэцэрлэг, сургуулийн суралцагсдын нас сэтгэхүйд тохирсон эрүүл мэндийн зөв дадал, хэвшлийг бэхжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шаардлагатай эмч, сэтгэл зүйчийг ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.15. Багшийг дахин сургах, гадаад, дотоодод сургах, туршлага судлах хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- 1.1.16. Орон нутгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан шинжлэх ухааны нээлт, бүтээлийг дэмжинэ.
- 1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, эрүүл мэндээ хамгаалах бодлогын шинэчлэл хийнэ.**
- 1.2.1. Эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцөлийг бий болгоно.
- 1.2.2. Эмч, эмнэлгийн ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулах бодлого баримтална.
- 1.2.3. Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт нэвтрүүлнэ.
- 1.2.4. Сэтгэл зүйн зөвлөгөө, тусlamж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- 1.2.5. Архи, тамхи, электрон тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулах, тэдгээрийн хор уршгийг сурталчилсан үүсмэл зан заншлыг халах, сэтгэц, донтолтын эмчилгээг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.2.6. Эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургалт, гадаад болон дотоод туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.2.7. Эрүүл мэндийн салбарт оруулах дотоод, гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална.
- 1.2.8. “Эрүүл мэнд эрхэм баян” хөтөлбөрөөр ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг ойртуулж, амьдралын чанарыг нь дээшлүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.9. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн чанар, стандартыг сайжруулах, үйлчлүүлэгсдийн болон ажиллагсдын үйлчилгээний болон ажлын таатай орчныг бүрдүүлэхэд анхаарна.
- 1.2.10. Иргэдийнхээ эрүүл мэндийн зөв боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг нэмэгдүүлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, идэвхтэй амьдрал, зөв дадал хэвшлийг хөхүүлэн дэмжиж, шаардлагатай орчин, нөлөөллийн төрөл бүрийн арга хэмжээг дэмжсэн ажлууд хэрэгжүүлнэ.
- 1.2.11. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийг нэн шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж, автомшинаар хангахад анхаарч ажиллана.
- 1.2.12. Бүс нутгийн хэмжээн дэх хорт хавдрын өвчлөлийн тоог бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.13. Залуусын болон нийт иргэдийн нөхөн үржихүйн боловсрол, өвчлөлийн тоог бууруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.14. Эмийн чанар, зүй зохистой хэрэглээний талаар бодлого хэрэгжүүлж ажиллана.

**1.3. Идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир, спортын төрлүүдийг дэмжинэ.**

1.3.1. Бүх нийтийн эрүүл мэнд, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэвшлийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаануудыг дэмжинэ.

1.3.2. Иргэдийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлага хангасан зориулалтын талбай, зам, тусгай орчныг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Бүх нийтийг хамарсан төрөл бүрийн спортын арга хэмжээнүүдийг дэмжин ажиллана.

1.3.3. Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэх, спортын төрөл бүрийн клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлнэ.

1.3.4. Спортын төрлүүдээр өндөр амжилт гаргах боломжтой суралцагсдын тоог нэмэгдүүлж, амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг дэмжиж ажиллана.

**1.4. Хүний хөгжил хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн бодлого**

1.4.1. Нийгмийн бүлгүүдэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогыг хүртээмжтэй, үр дүнтэй, оновчтой шуурхай зохион байгуулах бодлого баримтална.

1.4.2. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллын бодлого хэрэгжүүлж, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт ~~60 хэрэг 00002 3001034~~ хөдөлмөр эрхлэлтийн тэвчишгүй хэлбэрүүдтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлэх, шаардлагатай нөөц, нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

1.4.3. Ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж тэдэнд чиглэсэн соёлын болон эрүүл мэндийн хэрэгцээт үйлчилгээг хүргэхэд хамтран ажиллана.

1.4.4. Нэн шаардлагатай мэдлэг, туршлага бүхий ахмадуудын Зөвлөх хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож хамтран ажиллана.

1.4.5. Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.4.6. Малчид, мал аж ахуйн хөдөлмөр эрхлэгчдийн ахуй соёл, нийгмийн хангамжийг оновчтой, шинэ шатанд гаргах бодлого баримтална.

1.4.7. Бүс нутгийн болон орон нутагт нэн шаардлагатай байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байран дээр сургах аливаа хэлбэрийн сургалтыг дэмжих замаар ажлын байрыг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

1.4.8. Төр, хувийн хэвшил, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг оновчтой зохицуулах, дэмжих замаар ажлын байр нэмэгдүүлэх.

1.4.9. Иргэдийн давхар орлого олох хуульд нийцсэн аливаа хэлбэрийг дэмжих замаар орлогожуулах бодлого хэрэгжүүлнэ.

- 1.4.10. Иргэдийнхээ өөртөө ажлын байр бий болгож буй аливаа хуульд нийцсэн үйл ажиллагааг дэмжиж, ажиллах орчин, бодлогын зохицуулалтыг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.4.11. Орлого бага иргэн, өрхийг бүс нутгийн болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн төсөл хөтөлбөрт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох замаар ажлын байранд бэлтгэж, тогтвортой ажлын байртай болоход хамтран ажиллана.
- 1.4.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил хөдөлмөрт бэлдэх, ажлын байраар хангагдах, ажлын ээлтэй орчин бүрдүүлэх, өөртөө ажлын байр бий болгоход бүхий л талаар дэмжиж ажиллана.

#### **1.5. Үндэсний өв соёл дээдлэн дэлгэрүүлж, аймаг, орон нутгийн соёл урлагaa дэмжинэ.**

- 1.5.1. Соёл урлагийн байгууллагын уран бүтээл, соёлын хөтөлбөр арга хэмжээг иргэдийн хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 1.5.2. Үндэсний өв соёл, ахуй, уламжлал, аймаг орон нутгийн онцлог шингэсэн соёлын уран бүтээл, дижитал болон шинэлэг бүтээлүүдийг дэмжиж ажиллана.
- 1.5.3. Биет болон биет бус өв, өв тээгчдийг уламжлах, түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн бүртгэл, хамгаалалтыг төгөлдөршүүлэхэд анхаарна.
- 1.5.4. Номын сан, музейн орчны хамгаалалт, үзмэр, ном товхимлын тоог нэмэгдүүлэх, виртуаль болон дижитал хэлбэрт оруулж түгээн дэргэрүүлэхэд анхаарч ажиллана.

ДЮА0052 9001034

#### **2. “БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО -**

- 2.1. Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна
  - 2.1.1. Иргэн бүрд жигд боломж, нөхцөлийг олгож Архангай аймгийн эдийн засгийг олон тулгуурт, оновчтой төлөвлөлт бий болгох замаар дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөн нэмэгдүүлнэ. Сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
  - 2.1.2. Салбарын болон бус, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцоолж, нийгэм, эдийн засгийн хөгжилд түлхэц болох аймаг, орон нутгийн бизнес, инноваци, эхлэлийн бизнесийг дэмжин хөгжүүлэх, урамшуулах таатай орныг бүрдүүлэх, төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр болон санхүүжилтийг ил тод болгоход анхаарч ажиллана.
  - 2.1.3. Бүс нутгийн онцлогт тохирсон жижиг, дунд үйлдвэрлэлийг сумдад барьж байгуулахад орон нутгийн зүгээс бодлогоор дэмжиж, тогтвортой, үр ашигтай ажиллах механизмыг бүрдүүлнэ.

- 2.1.4. Байгалийн нөөц түүний өгөөжийг иргэдийнхээ амьжирааг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон ажил, бизнес эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.
- 2.1.5. Иргэдийнхээ ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгох зорилт тавин шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, бүрэн хөдөлмөр эрхлэлттэй аймаг болохын төлөөх бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 2.1.6. Эрдэс баялгийн болон мал, малын гаралтай түүхий эд бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах, нийлүүлэх нэгдсэн тогтолцоог бүс нутгийн онцлогт үндэслэн бүрдүүлнэ. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
- 2.1.7. Уул уурхайн салбарт ~~хариуцлагатай~~, өгөөжтэй, шинэ технологи бүхий байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг явуулах, эдийн засгийн өсөлт, ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.8. Цэцэрлэг хотын эрчим хүч цахилгаан, дулаан, цэвэр ус, ариутгах татуургын инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг өргөтгөх, шинэчилж, энэ салбарт ухаалаг, хэмнэлттэй технологи нэвтрүүлнэ.
- 2.1.9. Цэцэрлэг хотын усан хангамжийн хоёрдогч эх үүсвэрийг хайх, барьж ашиглалтад оруулах, зарим томоохон сумдын усан хангамжийн нөөцийг тогтоох асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 2.1.10. Цэцэрлэг хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох замаар ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, боловсруулах цогц бодлогыг нэвтрүүлж, хог хаягдлын менежментийг ахисан түвшинд хүргэж байгаль орчинд ээлтэй, стандарт хангасан боловсруулалт хийх, менежментийг ахисан түвшинд хүргэх бодлого баримтална.
- 2.1.11. Улсын чанартай авто замын ойролцоо орших сумын төвүүдийг хатуу хучилттай замаар холбох ажлыг улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үе шаттай шийдвэрлэнэ.

## **2.2. Мал аж ахуйн эдийн засгийн үр ашгийг сайжруулж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.**

- 2.2.1. Хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйг тэргүүн ач холбогдол бүхий салбарын түвшинд авч үзэж хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.2.2. Уламжлалт нүүдлийн мал аж ахуй болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, хүн ам олноор суурьшсан аймаг, сумын төв, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимиийн чиглэлээр төрөлжсөн, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бодлого баримтална.

- 2.2.3. Малчин өрх, хоршоо, нөхөрлөл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангах, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн тааты нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлаг үзүүлж ажиллана.
- 2.2.4. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан бус болон төв, суурин газруудын ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.2.5. Арьс шир, мах, сүү, ноос зэрэг малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах санаа санаачилгыг дэмжиж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2.6. Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш оруудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлэх, мал, амьтны эмнэлгийн үйл ажиллагааг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулна.
- 2.2.7. Мал аж ахуй, хөдөө аж ахуйн эрүүл бусийг бий болгож, баталгаажуулна. Мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлоход тэргүүн ач холбогдол өгнө.
- 2.2.8. Сум болгонд малын эрүүл ахуйг хангах, түүхий эд цуглуулах төвүүдийг өмчийн олон хэлбэртэйгээр байгуулж хөдөө аж ахуйн биржтэй хослон ажиллуулах бодлого баримтална.
- 2.2.9. Мал аж ахуйг байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах зах зээлийн зарчимд нийцсэн даатгалын тогтолцоог дэмжиж малчдын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 2.2.10. Мал аж ахуйн салбарт “Монгол өрх - хөгжлийн загвар аж ахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд талуудын оролцоог ханган хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгч, зах зээлтэй тэднийг холбох кластерын платформыг хөгжүүлнэ. Мөн нийлүүлэлт, үйлдвэрлэл, логистик болон маркетингийн нэгдсэн систем бүхий платформыг үүсгэн байгуулна.

### **2.3. Бизнес эрхлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.**

- 2.3.1. Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчныг бүрдүүлж, компанийн засаглал, бизнесийн ёс зүйг сайжруулж, зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- 2.3.2. Мэдлэг, инновацийг дээдэлсэн эдийн засгийн ач холбогдолтой бизнесийн төслүүдийг дэмжинэ.

- 2.3.3. Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн аймгийн иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтална.
- 2.3.4. Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.3.5. Хөрсний үржил шимиийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.3.6. Хөдөө аж ахуйд суурилсан, нэмүү өртөг шингэсэн экспортын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шат руу шилжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжсэн бизнесийн орчныг бүрдүүлнэ.
- 2.3.7. Шударга өрсөлдөөнд суурилсан компани төвтэй кластерууд хөгжих боломжийг бүрдүүлж, мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээ, банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах хамтын ажиллагааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.3.8. Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангах, сум, суурин газрын бусэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа мах болон сүүний тодорхой хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах санаачилгыг дэмжинэ.
- 2.3.9. Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.10. Цахим худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, газарзүйн байдалтай холбоотой бизнесийн өртөг, зардлыг бууруулах бодлого баримтална.
- 2.3.11. “Сумын хөрөнгө оруулалтын сан”-гаар дамжуулан малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.12. Орлогын шинэ эх үүсвэр бий болгох боломжийг дэмжих, эмийн ургамлын төрөл зүйл нөөцийг түшиглэн үр бэлтгэх, таримал хэлбэрээр нутагшуулах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд төрөөс газрын асуудал болон санхүүжилтийн эх үүсвэрээр дэмжих бодлого баримтална.

## 2.4. Аялал жуулчлал

- 2.4.1. Манай аймгийн харьцангуй давуу тал болох аялал, жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, дотоодын болон экспортын орлогын тогтвортой эх үүсвэр болгох бодлого баримтална.

- 2.4.2. Аялал жуулчлалын үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлж, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.4.3. Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 2.4.4. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал, нүүдлийн соёл иргэншлийг танилцуулах жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.4.5. Орчин үетэй зохицон хөгжиж буй нүүдлийн соёл, ахуйтай танилцах болон байгаль орчинд ойр, эрүүл амьдралын хэв маягийг мэдрүүлсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.
- 2.4.6. Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншлыг хамарсан зөвлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.



### **3. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ**

#### **3.1. Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө**

- 3.1.1. Монголын уламжлалт нүүдлийн ахуйд цахим технологи, эрчим хүчний эх үүсвэр, цэвэр усан хангамж, түүхий эд боловсруулах бичил үйлдвэрлэл мэт орчин үеийн технологийн ололтыг нэвтрүүлэх, малчдын эрүүл, тохитой орчинд амьдрах, хөгжих, аж ахуй эрхлэх боломжийг сайжруулах, энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Хиймэл оюун ухаан, блокчэйн зэрэг аж үйлдвэржилтийн тавдугаар хувьсгалыг бий болгож буй шинэлэг технологиудыг эзэмших ур чадварыг хүүхэд залууст олгох зорилгоор хичээлийн хөтөлбөрт тусгаж өгнө. Чадварлаг боловсон хүчнийг дээрх чиглэлээр мэргэшин суралцахад тэтгэлэг олгоно.
- 3.1.3. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Орон нутгийн бүх түвшинд интернэт, компьютер, технологийн хэрэглээг түлхүү ашиглах, интернэт орчныг хямд, хурдтай байлгах, мэдээллийн технологи хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.1.4. Эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, бага, дунд оврын үүсгүүрийн технологи хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих бодлого баримтална.
- 3.1.5. Мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй дотоодын компаниуд, мэргэжлийн холбоодыг дэмжиж чадавхжуулах бодлого баримтална.
- 3.1.6. Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг орон нутагт бүрэн нэвтрүүлнэ. АЮА0052 9001034
- 3.1.7. Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулснаар иргэд хурдан шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, Төрийн бүх шатны үйлчилгээг цахимаар авахад интернет үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.8. Аймаг болон орон нутгийн төсөв, тэдгээрийн үйл ажиллагаанд иргэд цахимаар санал илгээх, оролцох, хяналт тавих нэгдсэн системийг бий болгоно.
- 3.1.9. Технологийн боловсрол, тэр дундаа мэдээллийн технологийн боловсролыг бага наснаас эхлэн бүх шатны сургалтын агуулгад системтэйгээр түлхүү оруулах бодлого баримтална.
- 3.1.10. Технологийн боловсрол олгох зориулалттай лаборатори болон бусад сурхад орчныг орчин үеийн шийдлийг ашиглан сургалтын байгууллагуудад нэвтрүүлнэ.
- 3.1.11. Онлайн сургалт. Хөгжлийн хандлагыг даган танхимын бус, зөвхөн хүүхэд залуус биш бүх насны хүмүүст зориулсан онлайн, эчнээ

сургалтуудыг нэвтрүүлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх боломжийг технологид суурилан олноор бий болгоно.



## **4. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ХҮН НОГООН ХӨГЖЛИЙН ЗАГВАР**

**Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана**

### **4.1. Байгалийн нөөцийн болон бэлчээрийн менежмент**

- 4.1.1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.
- 4.1.2. Биологийн олон янз байдал, экосистем, байгалийн үзэсгэлэнт газар, соёлын өвийг тодотгосон тогтвортой аялал жуулчлалын туршлага, санаачилгыг дэмжиж хөгжүүлнэ.
- 4.1.3. Аймгийн газар нутаг, бэлчээрийн өөрийнх нь сэргэх чадавх болон малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр, нутгийн тогтвортой ашиглалтыг хангах хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого баримтална.
- 4.1.4. Аймгийн хэмжээн дэх газар нутаг, бус дэх бэлчээрийн талхлагдал, дорийтол цаашид газар авахаас сэргийлэх, мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хангахад тулгуур ач холбогдол бүхий “Бэлчээрийн менежмент”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- 4.1.5. Ойжуулалт, нөхөн сэргээлт, тогтвортой газар тариалан эрхлэх зэрэг газрын тогтвортой менежментийн сайн туршлагыг дэлгэрүүлнэ. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх хөдөө аж ахуйн арга техникиг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийг шингээх, экосистемийн уян хатан чанарыг нэмэгдүүлэхийн тулд хөрс, газрыг хамгаалах хүчин чармайлтыг дэмжинэ.
- 4.1.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллана. Мод ургуулах ажлыг тодорхой хэмжээгээр бизнес, арилжааны хэлбэрт шилжүүлэх, гадаад дотоодын хувийн санхүүжилт, ногоон бонд, хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, дэмжих чиглэлээр анхаарч ажиллана.
- 4.1.7. Аймаг, орон нутгийн үл олборлогдох нөөц төдийгүй хөдөөгийн хөгжил, үндэсний соёлын өв болсон бэлчээр нутгаа хадгалан хамгаалах “Бэлчээр ашиглалтын хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- 4.1.8. Дахин сэргээгдэх ан агуурын нөөцийн менежментийг хөгжүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн эдийн засгийн үндсийг бүрдүүлж, орлогыг шударга хуваалцах, ил тод байх зарчмыг нэвтрүүлнэ.
- 4.1.9. Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах бодлогыг ядуурлыг бууруулах үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ.
- 4.1.10. Байгаль дахь хог хаягдлыг арилгах, түүж цуглуулах бодлогыг боловсронгуй болгож, аялал жуулчлалын болон байгаль орчны орлогоос хог хаягдлыг бууруулах менежментийг санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

- 4.1.11. Усны бохирдлыг бууруулна. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн зохих хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах аймгийн хэмжээний усан сан байгуулах арга хэмжээнүүдийг авч эхэлнэ.
- 4.1.12. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. Энэ салбар дахь ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлнэ.
- 4.1.13. Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлж, ариун цэврийн байгууламжийн шүүлтүүрийн үйл ажиллагааг сайжруулна.
- 4.1.14. Хаягдал усыг цэвэршүүлэх, саарал ус ашиглах, хурын усыг хуримтлуулах гэх мэт усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх арга хэмжээг авна.
- 4.1.15. Аймгийн төвийн ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, төв, суурин газрыг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг бууруулах бодлогыг баримтална.
- 4.1.16. Уур амьстгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын ~~байгууллагаар~~ дамжуулан олгох бодлого баримтална.
- 4.1.17. Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт малчин айлд очих, тодорхой хугацаанд ажиллаж, ахуй соёлоос суралцах байгаль орчноо хамгаалах агуулгыг нэвтрүүлэх асуудлыг дэвшүүлнэ.
- 4.1.18. Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлнэ.
- 4.1.19. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэй технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтална.

## **5. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- 5.1. Төрийн албан хаагчийг дэмжиж, төрийн үйлчилгээг шинэчлэх бодлого хэрэгжүүлж, цахимжуулна. Авлигын эсрэг нийтийн хөдөлгөөнийг дэмжинэ.**
- 5.1.1. Төрийн албыг улс төрийн нам, улс төрчдийн нөлөөлөл, дарамтаас ангижруулан, бүтэц, зохион байгуулалтын хувьд оновчтой болгож, орон тоог боломжит доод хэмжээнд хүртэл бууруулан бүтээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.1.2. Төрийн албан хаагчдыг бэлдэх, тасралтгүй давтан сургахад анхаарч ажиллана.
- 5.1.3. Төрийн жинхэнэ албан хаагч нь чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу ажиллах боловч төрийн албыг чадавхжуулж, хөдөлмөрийн зах зээл дээрээс шилдэг мэргэжилтнүүдийг татан оролцуулах боломжийг бүрдүүлэхийн тулд сонгон шалгаруулалтаар (тусгай шалгалт) төрийн албаны зохих түвшинд орж ажиллах бодлогийг хэрэгжүүлнэ.
- 5.1.4. Төрийн ёс зүй, сахилга бат, хариуцлага, мэдлэг чадвар, чармайлт бүхий төрийн тогтвортой албан хаагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт тавьж хэрэгжүүлнэ.
- 5.1.5. Төрийн албан хаагчид тавигдах шалгуурыг өндөрсгөх, тэднийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төрийн албан хаагчдын нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг нэмэгдүүлнэ.
- 5.1.6. Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- 5.1.7. Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтална.
- 5.1.8. Авлига, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх таслан зогсооход чиглэсэн нөлөөллийн болон бусад арга хэмжээг нийгмийн бүлгүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байдлаар зохион байгуулах арга хэмжээнүүд авна.
- 5.1.9. Уул уурхайн хөрөнгө оруулагчид орон нутагтай хамтран ажиллах нэрийдлээр орон нутгийн засаг захиргаа, иргэдэд шууд болон шууд бус татаас, хандив өгч авлигажсан сэтгэлгээ, орчин бүрдүүлдгийг цэгцэлж, илт тод, иргэдэд болон нийтэд өгөөжтэй болгон журамлах бодлогыг баримталж ажиллана.
- 5.1.10. Төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчмыг бодитой хэрэгжүүлж, төрийн болон байгууллагын иргэнд хамаарах ил тод байх мэдээ, мэдээллийг оруулах нөхцөлийг нэмэгдүүлж, иргэдийн мэдэх эрхийг хангана.

- 5.2. Үр дүнд чиглэсэн төсвийн сахилга батыг хангаж, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж олон нийтийн хяналтад оруулна.**

- 5.2.1. Үр дүнд чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлж, бүсчилсэн хөгжилд тулгуурласан засаг захиргааны оновчтой тогтолцоог нэвтрүүлэх замаар төсвийн урсгал зардлыг бодитоор бууруулна.
- 5.2.2. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн орлогоор төсөл, хөтөлбөр шууд санхүүжүүлдэг байдлыг зогсоож, бизнесийн зарчмаар бие даан үйл ажиллагаагаа ил тод явуулах нөхцөлийг хангаж, ашгийг ногдол ашиг хэлбэрээр төсөвт төвлөрүүлэх, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг төсвийн хүрээнд баталдаг байх бодлого баримтална.
- 5.2.3. Орон нутгийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар сонгон ажиллуулна. Хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлнэ.
- 5.2.4. Хууль эрх зүйн орчинд удирдлагын хариуцлагын хийдэл, үр ашиггүй зардлын хяналтыг сайжруулах бодлого баримталж, хуульд нийцсэн зөв удирдлага, хариуцлагын тогтолцоо бүхий загвар бий болгоно.
- 5.2.5. Орон нутгийн өмчит компаниудын хөрөнгө, үйл ажиллагаанд аудит хийх, санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлнэ.

### **5.3. Шударга, ёс зүйтэй Монгол нийгмийг бүрдүүлнэ.**

- 5.3.1. Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 5.3.2. Ёс зүйтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэх бодлого баримтална.
- 5.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Нийгмийн хөгжил дэвшилд жендерийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх орчныг бүрдүүлнэ.
- 5.3.4. Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.
- 5.3.5. Хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ.
- 5.3.6. Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.
- 5.3.7. Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих хяналтыг эрс чангатгана.

**ХҮН НАМ  
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НАМЫН ХОРОО**

**“ХҮНИЙ ХӨГЖИЛ НУТГИЙН ХӨГЖИЛ”  
2024-2028**

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХҮН НАМЫН ХОРООНООС  
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ЭРДЭНЭБУЛГАН СУМ  
2024 ОН**

## **1. “ХҮНИЙ ХӨГЖИЛ-НУТГИЙН ХӨГЖИЛ” ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

### **1.1. Хүндээ зориулсан хөрөнгө оруулалт-өрсөлдөх чадвартай боловсролын хүрээнд**

- 1.1.1. Цэцэрлэг, сургуулийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд мэргэжлийн байгууллагын дүгнэлт хийлгэж, хүүхдэд ээлтэй гадаад орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.2. “Хос хэлтэн” болох зорилт тавьж, зохих бэлтгэл ажлыг хэрэгжүүлнэ. Гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- 1.1.3. Цэцэрлэг, сургуулийн суралцагсдын нас сэтгэхүйд тохирсон эрүүл мэндийн зөв дадал, хэвшлийг бэхжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шаардлагатай эмч, сэтгэл зүйчийг ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.4. Багшийг дахин сургах, гадаад, дотоодод сургах, туршлага судлах хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

### **1.2. Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, эрүүл мэндээ хамгаалах бодлогын шинэчлэл хийнэ.**

- 1.2.1. Өрхийн эмнэлгүүдийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцөлийг бий болгоно.
- 1.2.2. Сумын болон өрхийн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анааах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулах бодлого баримтална.
- 1.2.3. Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- 1.2.4. Иргэдийнхээ эрүүл мэндийн зөв боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг нэмэгдүүлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, идэвхтэй амьдрал, зөв дадал хэвшлийг хөхүүлэн дэмжиж, шаардлагатай орчин, нөлөөллийн төрөл бүрийн арга хэмжээг дэмжсэн ажлууд хэрэгжүүлнэ.
- 1.2.5. Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийг нэн шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж, автомашинаар хангахад анхаарч ажиллана.

### **1.3. Идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир, спортын төрлүүдийг дэмжинэ.**

- 1.3.1. Иргэдийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж, шаардлага хангасан зориулалтын талбай, зам, тусгай орчныг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Бүх нийтийг хамарсан төрөл бүрийн спортын арга хэмжээнүүдийг дэмжин ажиллана.
- 1.3.2. Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэх, спортын төрөл бүрийн клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хөгжүүлнэ.

1.3.3. Спортын төрлүүдээр өндөр амжилт гаргах боломжтой суралцагсдын тоог нэмэгдүүлж, амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг дэмжиж ажиллана.

**1.4. Хүний хөгжил хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн бодлого**

1.4.1. Нийгмийн бүлгүүдэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогыг хүртээмжтэй, үр дүнтэй, оновчтой шуурхай зохион байгуулах бодлого баримтална.

1.4.2. Ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж тэдэнд чиглэсэн соёлын болон эрүүл мэндийн хэрэгцээт үйлчилгээг хүргэхэд хамтран ажиллана.

1.4.3. Иргэдийнхээ өөртөө ажлын байр бий болгож буй аливаа хуульд нийцсэн үйл ажиллагааг дэмжиж, ажиллах орчин, бодлогын зохицуулалтыг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил хөдөлмөрт бэлдэх, ажлын байраар хангагдах, ажлын ээлтэй орчин бүрдүүлэх, өөртөө ажлын байр бий болгоход бүхий л талаар дэмжиж ажиллана.

**1.5. Үндэсний өв соёл дээдлэн дэлгэрүүлж, аймаг, орон нутгийн соёл урлагaa дэмжинэ.**

1.5.1. Үндэсний өв соёл, ахуй, уламжлал, аймаг орон нутгийн онцлог шингэсэн соёлын уран бүтээл, дижитал болон шинэлэг бүтээлүүдийг дэмжиж ажиллана.

1.5.2. Биет болон биет бус өв, өв тээгчдийг уламжлах, түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн бүртгэл, хамгаалалтыг төгөлдөршүүлэхэд анхаарна.

1.5.3. Номын сан, музейн орчны хамгаалалт, үзмэр, ном товхимлын тоог нэмэгдүүлэх, виртуаль болон дижитал хэлбэрт оруулж түгээн дэргэрүүлэхэд анхаарч ажиллана.

**2. “БИЗНЕС, ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО -**

**2.1. Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна**

2.1.1. Бүс нутгийн онцлогт тохирсон жижиг, дунд үйлдвэрлэлийг суманд барьж байгуулахад орон нутгийн зүгээс бодлогоор дэмжиж, тогтвортой, үр ашигтай ажиллах механизмыг бүрдүүлнэ.

2.1.2. Байгалийн нөөц түүний өгөөжийг иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон ажил, бизнес эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.

2.1.3. Цэцэрлэг хотын эрчим хүч цахилгаан, дулаан, цэвэр ус, ариутгах татуургын инженерийн дэд бүтэц, шугам сүлжээг өргөтгөх, шинэчилж, энэ салбарт ухаалаг, хэмнэлттэй технологи нэвтрүүлнэ.

- 2.1.4. Цэцэрлэг хотын усан хангамжийн хоёрдогч эх үүсвэрийг хайх, барьж ашиглалтад оруулах, зарим томоохон сумдын усан хангамжийн нөөцийг тогтоох асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 2.1.5. Цэцэрлэг хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох замаар ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, боловсруулах цогц бодлогыг нэвтрүүлж, хог хаягдлын менежментийг ахисан түвшинд хүргэж байгаль орчинд ээлтэй, стандарт хангасан боловсруулалт хийх, менежментийг ахисан түвшинд хүргэх бодлого баримтална.

## **2.2. Мал аж ахуйн эдийн засгийн үр ашгийг сайжруулж, малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.**

- 2.2.1. Малчин өрх, хоршоо, нөхөрлөл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангах, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

## **2.3. Бизнес эрхлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.**

- 2.3.1. Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.3.2. Хөрсний үржил шимиийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.3.3. Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.4. Цахим худалдаа, үйлчилгээг хөгжүүлж, газарзүйн байдалтай холбоотой бизнесийн өртөг, зардлыг бууруулах бодлого баримтална.
- 2.3.5. “Сумын хөрөнгө оруулалтын сан”-гаар дамжуулан малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

## **2.4. Аялал жуулчлал**

- 2.4.1. Манай аймгийн харьцангуй давуу тал болох аялал, жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, дотоодын болон экспортын орлогын тогтвортой эх үүсвэр болгох бодлого баримтална.
- 2.4.2. Аялал жуулчлалын үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлж, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.4.3. Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншлыг хамарсан зөвлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.

### **3. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ ЭЗЭМШИХ**

#### **3.1. Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үетэй хөл нийлүүлж хөгжинө**

- 3.1.1. Эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, бага, дунд оврын үүсгүүрийн технологи хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих бодлого баримтална.
- 3.1.2. Төрийн байгууллагын үйлчилгээг цахимжуулснаар иргэд хурдан шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, Төрийн бүх шатны үйлчилгээг цахимаар авахад интернет үйлчилгээний нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### **4. БАЙГАЛЬД ОЙР МОНГОЛ ХҮН НОГООН ХӨГЖЛИЙН ЗАГВАР**

**Унаган байгаль ба түргэн хөгжлийг хослуулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана**

#### **4.1. Байгалийн нөөцийн болон бэлчээрийн менежмент**

- 4.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллана. Мод ургуулах ажлыг тодорхой хэмжээгээр бизнес, арилжааны хэлбэрт шилжүүлэх, гадаад дотоодын хувийн санхүүжилт, ногоон бонд, хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, дэмжих чиглэлээр анхаарч ажиллана.
- 4.1.2. Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах бодлогыг ядуурлыг бууруулах үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ.
- 4.1.3. Эрүүл ахуйн шаардлагад ~~нийцсэн~~ ~~ундны~~ усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. Энэ салбар дахь ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлнэ.
- 4.1.4. Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлж, ариун цэврийн байгууламжийн шүүлтүүрийн үйл ажиллагааг сайжруулна.
- 4.1.5. Хаягдал усыг цэвэршүүлэх, саарал ус ашиглах, хурын усыг хуримтлуулах гэх мэт усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх арга хэмжээг авна.
- 4.1.6. Аймгийн төвийн ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт ~~нийцсэн~~ дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, төв, суурин газрыг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг бууруулах бодлогыг баримтална.
- 4.1.7. Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлнэ.
- 4.1.8. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтална.

## **5. ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

**5.1. Төрийн албан хаагчийг дэмжиж, төрийн үйлчилгээг шинэчлэх бодлого хэрэгжүүлж, цахимжуулна. Авлигын эсрэг нийтийн хөдөлгөөнийг дэмжинэ.**

- 5.1.1. Төрийн албыг улс төрийн нам, улс төрчдийн нөлөөлөл, дарамтаас ангижруулан, бүтэц, зохион байгуулалтын хувьд оновчтой болгож, орон тоог боломжит доод хэмжээнд хүртэл бууруулан бүтээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.1.2. Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтална.
- 5.1.3. Төрийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчмыг бодитой хэрэгжүүлж, төрийн болон байгууллагын иргэнд хамаарах ил тод байх мэдээ, мэдээллийг оруулах нөхцөлийг нэмэгдүүлж, иргэдийн мэдэх эрхийг хангана.

**5.2. Үр дүнд чиглэсэн төсвийн сахилга батыг хангаж, төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж олон нийтийн хяналтад оруулна.**

- 5.2.1. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компанийн орлогоор төсөл, хөтөлбөр шууд санхүүжүүлдэг байдлыг зогсоож, бизнесийн зарчмаар бие даан үйл ажиллагаагаа ил тод явуулах нөхцөлийг хангаж, ашгийг ногдол ашиг хэлбэрээр төсөвт төвлөрүүлэх, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг төсвийн хүрээнд баталдаг байх бодлого баримтална.
- 5.2.2. Орон нутгийн өмчит компаниудын хөрөнгө, үйл ажиллагаанд аудит хийх, санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлнэ.

**5.3. Шударга, ёс зүйтэй Монгол нийгмийг бүрдүүлнэ.**

- 5.3.1. Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 5.3.2. Ёс зүйтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэх бодлого баримтална.
- 5.3.3. Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.
- 5.3.4. Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих хяналтыг эрс чангатгана.